

Ерөнхийлөгч Томас С.Монсон



Биднийг удирдах бошиглогчид

Хэдэн жилийн өмнө би Тэргүүн Зөвлөл болон Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын долоо хоногт нэг удаа уулздаг Солт Лэйкийн ариун сүмийн өрөөнд сууж байлаа. Би Тэргүүн Зөвлөл рүү харсан хана руу ширтээд, ханан дээрх Сүмийн ерөнхийлөгч бүрийн хөргийг ажигласан юм.

Би өмнөө байгаа тэднийг ажиглан суухдаа бошиглогч Иосеф Смитээс (1805–44) авахуулаад Гордон Б.Хинкли (1910–2008) хүртэлх “бошиглогч бүрийн удирдамжид хэчнээн талархдаг” тухайгаа бодсон.

Тэд бол хэзээ ч гуйвж, эргэлзэж мөн уруудаж байгаагүй эрчүүд. Тэд бол Бурханы эрс. Би таньдаг, хайрладаг байсан орчин үеийн бошиглогчдынхоо тухай бодохдоо тэдний амьдрал, зан байдал, сүнслэгээр өдөөгдсөн сургаалуудыг эргэн санасан.

Намайг төрөх үед ерөнхийлөгч Хибэр Ж.Грант (1856–1945) Сүмийн ерөнхийлөгч байсан юм. Би Түүний амьдрал болоод сургаалын талаар бодон, ерөнхийлөгч Грантын байнга үлгэр жишээ үзүүлдэг байсан нэгэн зан чанар бол сайн сайхан, журамт аливаа зүйл рүү үргэлж цөхрөлтгүй тэмүүлэх явдал байсан гэдэгт итгэдэг.

Намайг Солт Лэйк хотод тойргийнхоо бишопоор үйлчилж байх үед ерөнхийлөгч Жорж Албэрт Смит (1870–1951) Сүмийн ерөнхийлөгч байлаа. Тэрээр Их Эзэн, дайсан хоёрын хооронд нэгэн агуу олс татах тэмцээн болж байгааг ажиглажээ. “Хэрэв та нар Их Эзэний талд зогсох юм бол түүний нөлөөн доор байж, бурууг хийх хүсэлгүй байх болно” гэж тэр заасан.¹

1963 онд ерөнхийлөгч Дэвид О.Маккэй (1873–1970) намайг Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүнээр үйлчлүүлэхээр дуудсан юм. Тэр өөрийн амьдралын хэв маягаар бусдыг хэрхэн халамжлах тухай заасан. Тэрээр “жинхэнэ Христийн шашин бол үйлдэлд суурилсан хайр байдаг юм”² гэж заасан.

Сүмд хамгийн бүтээл арвинтай зохиолчдын нэг болох ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит (1876–1972) сайн мэдээний эрдэм мэдлэгийг амьдралынхаа зарчим болгосон хүн юм. Тэр судруудыг тогтмол уншдаг байсан бөгөөд доторх сургаалыг миний мэдэх хэнээс ч илүү мэддэг байлаа.

Ерөнхийлөгч Харолд Б.Лий (1899–1973) намайг жаахан хөвгүүн байх үед манай гадасны ерөнхийлөгчөөр үйлчилж байв. “Ариун газруудад зогсогтон та нар, мөн бүү шилжин нүүлгэгд”³ гэдэг нь түүний дуртай эшлэл байсан. Тэрээр гэгээнтнүүдийг Ариун Сүнсний шивнээг сонсож, хариулах хэмнэлтэй байхад урамшуулан дэмжсэн.

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбаллын (1895–1985) амьдралын гол зарчим нь өөрийгөө бүрэн зориулах явдал байсан гэдэгт би итгэдэг. Тэрээр өөрийгөө Их Эзэнд бүрэн, тодорхой зориулдаг байлаа. Тэр мөн сайн мэдээний дагуу амьдрахад өөрийгөө зориулсан.

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон (1899–1994) Сүмийн ерөнхийлөгч болох үедээ намайг Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөхөөр үйлчлүүлэхээр дуудсан юм. Тэрээр хайрыг гол зарчмаа болгосон бөгөөд энэ нь ч “Та нар ямархуу маягийн хүмүүс байвал зохих билээ?

Үнэнээр би та нарт хэлье, бүр миний адил буюу”⁴ гэх Аврагчийн хэлсэн, түүний дуртай шүлгээс харагддаг.

Ерөнхийлөгч Ховард В.Хантэр (1907–95) бусдаас үргэлж хамгийн сайн сайхныг нь олж хардаг байсан ба үргэлж эелдэг, даруу байсан. Түүний хоёрдугаар зөвлөхөөр үйлчлэх нь миний хувьд онцгой боломж байв.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли бидэнд хамгийн сайнаараа хийхийг заадаг байсан. Тэрээр Аврагчийн талаар мөн Түүний номлолын талаар хүчирхэг гэрчлэлээ хуваалцаж, бидэнд хайраар заасан. Түүний нэгдүгээр зөвлөхөөр үйлчлэх нь миний хувьд нэр төрийн хэрэг төдийгүй адислал байсан билээ.

Аврагч бидэнд хайртай учраас бидэн рүү бошиглогчдыг илгээдэг. Энэ 10-р сарын Ерөнхий чуулганаар Сүмийн ерөнхий эрх мэдэлтнүүд Түүний үгийг дахин хуваалцах онцгой эрхээ эдлэх болно. Бид энэхүү үүрэг хариуцлагадаа маш хянамгай, даруу ханддаг.

Есүс Христийн сэргээгдсэн Сүм дэлхий дээр байгаа нь мөн Сүм илчлэлтийн суурин дээр баригдсан байгаа нь ямар агуу адислал вэ! Үргэлжлэн ирэх илчлэлт бол Есүс Христийн сайн мэдээний нэгэн амин чухал хэсэг билээ.

Бид Ерөнхий чуулганаар арвин их хувийн илчлэлт хүлээн авахаар бэлтгэх болтугай. Бид амьд бошиглогч, төлөөлөгчдийг дэмжихээр гар өргөн батлахдаа зориомог шийдэмгий байх болтугай. Бид тэдний захиасыг сонссоноор гэгээрч, өргөгдөн, тайтгарч, хүчирхэгжих болтугай. Бид өөрсдийгөө Их Эзэн Есүс Христэд буюу Түүний сайн мэдээ болон ажилд өргөл болгон өргөж, зарлигуудыг нь шийдэмгий дагаж, хүслийг нь биелүүлэхээ дахин дахин амлах болтугай.

ЭШЛЭЛҮҮД

1. *Teachings of Presidents of the Church: George Albert Smith* (2011), 191.
2. *Teachings of Presidents of the Church: David O. McKay* (2003), 181.
3. Сургаал ба Гэрээ 87:8.
4. 3 Нифай 27:27.

ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААСНААР

Ерөнхийлөгч Монсон өмнөх бошиглогчдоос сурсан хүчирхэг сургамжуудаа хуваалцлаа. Тэрээр бидэнд “Аврагч бидэнд хайртай учраас бошиглогчдыг

илгээдэг” гэдгийг сануулсан. Та зааж буй хүмүүстээ тохинуулахдаа бошиглогч, төлөөлөгчид хэрхэн Бурханы биднийг гэх хайрын бэлгэ тэмдэг болдог тухай ярилцаж болно. Хамгийн сүүлийн Ерөнхий чуулганаас ерөнхийлөгч Монсоны нэг зөвлөгөөг хуваалцах талаар бодож үз. Зааж буй хүмүүст тань онцгой сэтгэгдэл төрүүлж, сүнсээр өдөөн, Аврагчийн хайрыг мэдрэхэд тусалсан үгсийг эргэн уншсанаар Ерөнхий чуулганд бэлтгэхэд тэднийг урь.

ЭСВӨР ҮЕИЙНХЭН

Бурхан минь бошиглогч илгээсэн танд талархъя

Бидний бошиглогч, ерөнхийлөгч Томас С.Монсон та нарт хэрхэн нөлөөлсөн бэ? Та түүний талаар юуг хамгийн их санах вэ? Та ерөнхийлөгч Монсон болон түүний амьдралын тухай тэмдэглэлийн дэвтэртээ бичих талаар бодож үзээрэй. Тэрээр санан дурсдаг бошиглогч *бүрийнхээ* өөрт нь үзүүлсэн нөлөөг уг захиаст тайлбарласан.

Та түүний хэлсэн үгнүүдээс дуртай эшлэлээ сонгоод, өрөөндөө хичээлийнхээ дэвтэр эсвэл цаасан дээр бичиж, ойр ойрхон харж болно. Та нар зурагтай эшлэл хийгээд, утасныхаа дэлгэцийн зураг болгон тавьж болно. Та нар эшлэлийг харах бүрдээ амьд бошиглогч хэчнээн чухал болохыг тунгаан бодож, өнөөдөр тэр бид бүхнийг хайрлаж, удирдахын төлөө байдаг гэдгийг санаж болно.

Та нар “Бурхан минь бошиглогч илгээсэн танд талархъя” дууллын аяыг [lds.org/go/9176](https://www.lds.org/go/9176)-аас татан авч болно.

ХҮҮХДҮҮД

Бошиглогчид биднийг Христ рүү удирддаг.

Аврагч бидэнд хайртай учраас бошиглогчдыг өгсөн. Бошиглогчдыг дагах нь бидэнд зөвийг сонгоход тусалдаг. Та нар бошиглогчийг дагахын тулд ямар хоёр зүйлийг хийж чадах вэ?



Нэг зүрх сэтгэлтэй

Энэ материалыг залбирч судлаад, юу хуваалцахаа мэдэхийн тулд сүнслэг өдөөлт эрэлхийл. Халамжийн нийгэмлэгийн зорилгыг ойлгох нь Бурханы охидыг мөнх амьдралын адислалуудад хэрхэн бэлтгэх вэ?

Итгэл, гэр бүл, халамж

“Их Эзэн өөрийн хүмүүсийг Сион хэмээн нэрлэв, учир нь тэд нэг зүрх сэтгэл мөн нэг оюунтай байлаа, мөн зөв шударга ёсонд оршин сууж байлаа; мөн тэдний дунд ядуус байсангүй” (Мосе 7:18). Бид хэрхэн нэг болох вэ?

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч М.Рассэлл Баллард “Цагаатгал хэмээх англи үгийн зүрхэнд нэг гэсэн утга байдаг. Хэрэв хүн төрөлхтөн үүнийг ойлгодог байсан бол бид нас, хүйс, арьс өнгө, шашин шүтлэг, нийгэм, эдийн засгийн байдлаас үл хамааран бүх хүнд санаа тавих байсан. Бид Аврагчийг даган дуурайж, бусдад хэзээ ч эелдэг бус, хүндэтгэлгүй, хэнэггүй, хайнга хандахгүй байх байсан”¹ гэжээ.

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх ерөнхийлөгч Хэнри Б.Айринг “Хүмүүс сүнстэй байгаа үедээ эв нэгдэлтэй байхыг хүсэн хүлээж болно. . . . Бурханы Сүнс хэзээ ч зөрчилдөөнийг үүсгэдэггүй (3 Нифай 11:29-ийг үзнэ үү) . . . бөгөөд хувийн амар амгалан,

нэгдмэл байдлыг авчирдаг”² хэмээн заасан юм.

Халамжийн нийгэмлэгийн нэгдүгээр зөвлөхөөр үйлчилж байсан Кэрол М.Стэфэнс олон сорилтын талаар ийнхүү дурдсан. “Би хэзээ ч нөхрөөсөө салж, хаягдсанаас үүдэх шаналлыг үүрч, хүнд хэцүү байдалд орж, ганц бие үлдсэнээр ирэх үүрэг хариуцлагыг үүрч байгаагүй. Би хэзээ ч хүүхдээ алдаж, жирэмсэн болж чадахгүй зовж эсвэл ижил хүйстэндээ сэтгэл татагдаж байгаагүй. Би хэзээ ч хүчирхийлэлд өртөж, хүндээр өвдөж эсвэл ямар нэгэн зүйлд донтож байгаагүй. Дээрх зүйлс намайг өсгөж, хөгжүүлж байсан зүйлс биш юм.

. . . Гэхдээ би . . . өөрийнхөө туулж өнгөрүүлсэн хувийн сорилт, бэрхшээлүүдээр дамжуулан . . . бүхнийг ойлгодог Нэгнийг илүү сайн мэддэг болсон. . . . Түүнчлэн би дээр дурдсан мөнх бус амьдралын шалгууруудыг охин, ээж, эмээ, эгч, авга эгч, найзаараа дамжуулан туулсан билээ.

Бурханы гэрээгээ сахигч охидын хувьд бидний боломж зөвхөн өөрсдөд маань ирэх бэрхшээлээс сурах төдий зүйл биш бөгөөд Бурханы гэр бүлийн бусад гишүүн маань хүнд хэцүүг туулах үед тэднийг дэмжин хайр энэрлээ үзүүлж мөн тэднийг ойлгох сэтгэлээр нэгдэх ёстой юм.”³

Нэмэлт судар болон мэдээлэл

Иохан 17:20–23; Ефес 4:15; Мозая 18:21–22; 4 Нифай 1:15
reliefsociety.lds.org

ЭШЛЭЛҮҮД

1. М.Рассэлл Баллард, “The Atonement and the Value of One Soul,” *Liahona*, 2004 оны 5-р сар, 86.
2. Хэнри Б.Айринг, “That We May Be One,” *Ensign*, 1998 оны 5-р сар, 67.
3. Кэрол М.Стэфэнс, “Бурханы гэр бүл,” 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 129.

Үүнийг эргэцүүлэн бод

Нэг нэгэнтэйгээ нэгдмэл байх нь хэрхэн Бурхантай нэг болоход тусалдаг вэ?